ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Үндэсний Аудитын газрын үйл ажиллагааны 2015 оны төлөвлөгөөний дагуу хийсэн НИЙЦЛИЙН АУДИТ

АЙМГИЙН ОРОН СУУЦНЫСАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Зохион байгуулалтын нэгж: **НИЙЦЛИЙН АУДИТЫН БАГ**

Аудитын код: **ҮАГ-НАГ/2015/04-НА-ХЭ**

Аудитын нэр: **Орон сууцны сангийн үйл ажиллагааны үр дүн**

Өндөрхаан хот
2015 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
ҮАГ-ын харъяа Хэнтий аймгийн Аудитын газар **Тэргүүлэх Аудитор** Ц.Энхтүвшин **Аудитын менежер** Б.Наранцэцэг **Ахлах аудитор** Х.Еркегүл **2015 оны 09 дүгээр сар** Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудал байвал 70562147, 98332147 дугаарын утас, 70562112 дугаарын факсаар харилцана уу ***ХАЯГ:*** **Хэнтий аймаг Хэрлэн сум** **Аймгийн ЗДТГ-ын байр325 тоот**	**Бүлэг 1** ***Орон сууцны сангийн журам боловсруулах шийдвэр гарсан боловч хэрэгжээгүй байна.***	5
	○ ***Аймгийн Орон сууц сангийн үйл ажиллагааг зохицуулах журам боловсруулах шийдвэр гарсан боловч хэрэгжээгүй байна.***	
	○ ***Хууль, дүрэм, журмууд нь сангийн үйл ажиллагааг зохицуулж байна***	
	Бүлэг 2 ***Орон сууцны сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах төлөвлөгөө, хөтөлбөргүй байна.***	6
	○ ***Аймгийн орон сууц сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.***	
	○ ***Сангийн хөрөнгийг бүрдүүлэх талаар ажил хийгдээгүй байна.***	
	Бүлэг 3 ***Орон сууцны сангийн хөрөнгийн 85,7 хувь нь үр дүн гараагүй байна.***	6
	○ ***Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэхгүй байна.***	
	○ ***Төсөл хөтөлбөрийг ТБОНӨХБАУХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.***	
	○ ***Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр нь зорилтот үр дүндээ хүрээгүй байна.***	
	Бүлэг 4 ***Орон сууцны сангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтын тогтолцоо бий боловч хяналт хийгдээгүй байна.***	
	○ ***Дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн байна.***	8
	○ ***Аймгийн Орон сууцны сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдэгүй байна.***	
	○ ***Орон сууцны сангийн мэдээллийг шилэн дансанд байршуулах боломжгүй байсан байна.***	
	Дүгнэлт.....	9
	Зөвлөмж.....	10
	Холбогдох байгууллагын санал:	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын их хурал
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗД	Засаг дарга
СТС	Санхүү төрийн сан

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 17-ны 20 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий Аудиторт Үндэсний аудитын газраас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн Тэргүүлэх Аудиторын 2015 оны 1 дүгээр сарын 27-ны 05 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г үндэслэн “Төрийн аудитын тухай” хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт:

Орон сууц сангийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- *Орон сууцны сангаас санхүүжүүлэхээр ажил төлөвлөсөн эсэх.*
- *Орон сууцны сангийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх.*
- *Орон сууцны сангийн хөрөнгөнд тавих дотоод хяналт үр дүнтэй эсэх,*

3. Аудитад хамрагдсан хүрээ:

Аудитаар 2014 оны аймгийн Орон сууц сангийн хөрөнгийнзаруулалт,бусад шаардлагатай баримт бичгүүдийг хамруулан, аймгийнЗДТГ-ын СТС-гийн хэлтэс болон бусад холбогдох байгууллагуудыг хамрууллаа.

4. Аудитын арга зүй:

Аудитын явцад аймгийн ЗДТГ, холбогдох агентлагийн албан тушаалтнуудтай ярилцан, асуулга лавлагаа, тодруулга авч, байгууллагын худалдан авалт болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, судалгаа гарган, тайлан бичиж, дүгнэлт, зөвлөмж боловсруулаа.

5. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

a. Төрийн аудитын тухай хууль,
b. Төсвийн тухай хууль,

c. Монгол улсын 2014 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
d. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль,
e. Орон сууцны тухай хууль,
f. ТБОНӨХБАҮХАТХууль,
g. Бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм нормативууд,

6. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг менежер Б.Наранцэцэгхянан удирдаж,ахлах аудитор Х.Еркегүл хийж гүйцэтгэлээ.

7. Аудитын хугацаа.

Аудитыг 2015 оны 07-р сарын 09-нд эхлэж, 2015 оны 09–р сарын 10-нд дуусгав.

8. Аудитын дүн.

Ерөнхий мэдээлэл

Аймгийн Орон сууц санд Улсын Орон сууц хөгжүүлэх сангаас 2014 онд санхүүжилт хийгдээгүй байна.

Аймгийн Орон сууцны сангаймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2004 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 05 дугаар тогтоолоор байгуулсан байна.

Аймгийн Орон сууцны сангийн санхүүгийн тайлангаар2014 оны эхэндхарилцах дансанд 32,0 сая төгрөг, байгууллагаас авах авлага дансанд 308,6 сая төгрөг, хүмүүсээс авах авлага дансанд 28,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байжээ. Харин 2014 онд харилцах дансаар 14,1 сая төгрөгийн орлого орж, 5,0 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж жилийн эцсийн байдлаар харилцах дансны үлдэгдэл 41,1 сая төгрөг, байгууллагаас авах авлага 308,6 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 10,2 сая төгрөг зэрэг сангийн нийт хөрөнгө нь 359,9 сая төгрөг байна.

БҮЛЭГ1: *Орон сууцны сангийн хөрөнгийн бүрдүүлэх, зарцуулах журам боловсруулах шийдвэр гарсан боловч хэрэгжээгүй байна.*

1.1 Аймгийн Орон сууцсангийн үйл ажиллагааг зохицуулахжурам боловсруулах шийдвэр гарсан боловч хэрэгжээгүй байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, ЗГ-ын 2002 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Орон сууц хөнгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдэлт, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журам”-нд сангийн үйл ажиллаганыэрх зүйн зохицуулалт хийгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчпийн 2013 оны 12 сарын 13-ны өдрийн №108 дугаар тогтоолд аймгийн Орон сууц хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах, Орон сууцны сангийн хөрөнгийг зарцуулах журам боловсруулж ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулах талаар тодорхой албан тушаалтнуудад үүрэг даалгавар өгсөн боловч одоо болтол тогтоол хэрэгжээгүй байна.

1.2 Хууль, дүрэм, журмууд нь сангийн үйл ажиллагааг зохицуулж байна.

Аймгийн Орон сууц сангийн үйл ажиллагааг зохицуулах журам боловсруулагдаагүй боловч ЗГ-ын 2002 оны 58 дугаар тогтоолоор баталсан“Орон сууц хөнгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдэлт, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журам”-аар зохицуулж байжээ.

БҮЛЭГ2: *Орон сууцны сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах төлөвлөгөө, хөтөлбөргүй байна.*

2.1Аймгийн орон сууц сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.

2014 онд аймгийн Орон сууцны сангаассанхүүжүүлэх төсөл, арга хэмжээ төлөвлөөгүй байна.

2.2 Сангийн хөрөнгийг бүрдүүлэхталаар ажил хийгдээгүй байна.

ЗГ-ын тусгай сангийн тухай хууль болон Аймгийн Орон сууцны санд 2014 онд 14,1 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Эх үүсвэрийн бүрдүүлэлтийг авч үзвэл орон сууц үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагч иргэдийн орон сууцны хангамж нөхцлийг сайжруулах зорилгоор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2008 оны 60 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад худалдсан орон сууцны үнийн эргэн төлөлтөөс бүрджээ. Энэ нь “Орон сууц хөнгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдэлт, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журам”-ын 9.г-д заасантай нийцэж байна.

БҮЛЭГ: Орон сууцны сангийн хөрөнгийн 85,7 хувь нь үр дүн гараагүй байна.

3.1 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэхгүйбайна.

Аймгийн Орон сууц сангаас 2014 онд 5,0 сая төгрөгийн буцалтгүй санхүүгийн дэмжлэг үзүүлжээ. Энэ нь “Орон сууц хөнгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдэлт, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журам”-ын 1-д “Иргэд, улсын болонхувийн аж ахуйн нэгж, байгууллага орон сууц худалдан авах, шинээр барих, засах, сайжруулахад” гэж заасантай нийцэж байгаа боловч уг журмын 17-д “Сан нь зохих шалгуурыг хангасан арижааны банкаар дамжуулан зээл олгоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

3.2 Төсөл хөтөлбөрийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.

Тулга констракшн ХХК-тай 2011 оны 3 дугаар сарын 3 өдөр аймгийн Засаг даргаар баталгаажуулан “Хэрлэн суманд баригдах 72 айлын орон сууцнаас төрийн албан хаагчдад зориулж 28 айлын орон сууц захиалах талаар захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ”-г нээлттэй тендэр шалгаруулаагүй шууд гэрээ байгуулжаймгийн Орон сууцны сангаас 279,0 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Энэ нь ЗГ-ын 2004 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Орон сууцны сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журам”-ын 16-д “Нийтийн зориулалттай орон сууцны барилгын төсөл шалгаруулах, орон сууц барих гүйцэтгэгчийг сонгох, худалдан авахтай холбогдсон харилцааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай хуулиар зохицуулна”, 20-д “Сангийн хөрөнгийг энэ журмын 16-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно”, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2-д “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тэндер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

3.3 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр нь зорилтот үр дүндээ хүрээгүй байна.

2014 оны жилийн эцсийн Тулга констракшн ХХК-аас авах авлага 308,6 сая төгрөгийг авч үзвэл 2011 онд аймгийн Засаг даргаар баталгаажуулан “Хэрлэн суманд баригдах 72 айлын орон сууцнаас төрийн албан хаагчдад зориулж 28 айлын орон сууц захиалах талаар захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ” байгуулсан ба гэрээний үнийн дүн 930,1 сая төгрөг, дуусах хугацаа 2013.02.25, санхүүжилтын 30 хувь буюу нийт 279,0 сая төгрөгийг захиалагч албан хаагчдын банкнаас авах зээлээс буцаан авах нөхцөлтэйгээр 2011 онд 20 хувь буюу 211,0 сая

төгрөг, 2012 онд 10 хувь буюу 68,0 сая төгрөгийг тус тус аймгийн Орон сууцны сангаас санхүүжүүлэхээр гэрээнд заасан байна. Уг гэрээг 2012 онд "Хэрлэн суманд баригдах 72 айлын орон сууцны барилгын ажлыг гүйцэтгүүлэх талаар захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ" болгон шинэчилэн байгуулсан ба үүнд нийт талбай 3396,22 м^2, гэрээний нийт үнэ 2377,3 сая төгрөг болгож өөрчилсөн байна.

Аймгийн Орон сууцны сангаас гэрээнд заасны дагуу 2011 онд 211,0 сая төгрөг, 2012 онд 68,0 сая төгрөгийн санхүүжилтыг олгожээ. Гэтэл гэрээний хугацаа 2013 оны 2 дугаар сарын 25-нд дууссан боловч гэрээний хугацаандаа захиалсан орон сууцаа хүлээж аваагүй,Тулга констракшн ХХК нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

Мөн Б.Одгэрэлийн аймгийн Орон сууцны санд төлөх 29,6 сая төгрөгийг "Тулга констракшн" ХХК-ний харилцах дансанд данс андууран төлснийг 2012 оны санхүүгийн тайланд Тулга констракшн ХХК-аас авах авлагаар тусгаж залруулсан байна.

Нэхэмжлэгч байгууллага болон төлөгч байгууллагын хооронд үүссэн нийт 308,6 сая төгрөгийн өр, авлагын үлдэгдлийг "Тооцооны үлдэгдлийн баталгаа" үйлдэж, уг тооцоог 2013 оны 5 сарын 10-ны өдрийн дотор нэхэмжлэн авахаар тохиролцон нэхэмжлэгч байгууллага болон төлөгч байгууллагын нягтлан бодогч нар гарын үсэг зурж баталгаажуулсан боловч заасан хугацаандаа авлагыг барагдуулаагүй байна.

Авлагыг барагдуулах зорилгоор 2013 оны 6 сарын 26-нд аймгийн Засаг даргаар баталгаажуулан Тулга констракшн ХХК-тай "Хэрлэн суманд баригдах 96 айлын орон сууцаас төрийн албан хаагчдад зориулж 8 айлын орон сууц захиалах талаар захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ"-ний нийт үнэ 306,4 сая төгрөг, гэрээний дуусах хугацаа 2014 оны 11 сарын 26 өдөр байна. Уг гэрээний хугацаа дуусахад мөн адил гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй хэвээр байгаа нь сангийн хөрөнгийн 85,7 хувь буюу 308,6сая төгрөгийн үр дүн гараагүй байна.

БҮЛЭГ 4: *Орон сууцны сангийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтын тогтолцоо бий боловч хяналт хийгдээгүй байна.*

4.1 Дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

Төсвийн тухай хуулийн 69 зүйлийг үндэслэн аймгийн ЗД-ын 2014 оны 11 сарын А/582 дугаар захирамжаар Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт,дотоод аудитын алба байгуулагджээ.

Мөн аймгийн ЗДТГ-т Хяналт Шинжилгээ Үнэлгээний алба ажилладаг нь сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавих тогтолцоо бүрдсэн гэж үзэж байна.

4.2 Аймгийн Орон сууцнысангийн үйл ажиллагааныдотоод хяналт шалгалт хийгдэгүй байна.

Аймгийн Орон сууцны сангийн үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагуудаас хяналт, шалгалт хийсэн баримт байхгүй байна.

2014 оны жилийн эцсийн байдлаар төрийн албан хаагчдаас авах 10,2 сая төгрөг, Тулга констракшаас авах 308,6 сая төгрөг, нийт 318,8 сая төгрөгийн авлага үүсчээ. Үүнд:

№	Авлагын төрөл	Овог нэр	Гэрээний дүн /сая. Төгрөг/	Гэрээ дуусах хугацаа	2014 оны эцсийн үлдэгдэл /сая.төгрөг/
1	Хувь хүмүүсээс авах авлага	Ц.Цэвээн-Идэр	18,4	2012.07.01	1,8
2		Ж.Хэрлэнцэцэг	12,2	2008.10 сар	7,0
3		С.Мөнхзаяа	11,5	2008.10 сар	1,2
4		Д.Дашнамжилмаа			0,2
		Дүн			**10,2**
5	Байгууллагаас авах авлага	Тулга констракшн ХХК	306,4	2014.11.26	308,6
		Дүн			**308,6**
	Авлагын нийт дүн				318,8

Дээрхи хүснэгтээс дүгнэж үзэхэд гэрээний хугацаа дууссан байхад авлагыг барагдуулаагүй байгаа нь дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой юм.

4.3Орон сууцны сангийн мэдээллийг шилэн дансанд байршуулах боломжгүй байсан байна.

Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа тул 2014 оны мэдээллийг байршуулах боломжгүй байна. 2015 онд орон сууцны сангаас ажил гүйлгээ хийгдээгүй тул шилэн дансанд мэдээлэл тавигдаагүй байна.

2015 онд орон сууцны сангаас ажил гүйлгээ хийгдээгүй тул шилэн дансанд мэдээлэл тавигдаагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Аймгийн орон сууц хөгжүүлэх хөтөлбөр, Орон сууц сангийн хөрөнгийг зарцуулах журмыг боловсруулан батлуулаагүй байхад хөрөнгө зарцуулж байна.

2. Урьд онуудад Орон сууцны сангаас зарцуулсан хөрөнгийн үр дүн хангалтгүй байгаагаас их хэмжээний авлага үүссэн байна.
3. Аймгийн Орон сууцны сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтхийгдээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга Ж.Оюунбаатар танд:

1. Аймгийн Орон сууцны сангаас албан хаагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг таслан зогсоож, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах журмыг хууль тогтоомжинд нийцүүлэн боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

2. Аймгийн Орон сууцны сангийн авлагыг бүрэн барагдуулах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулж, хүргүүлсэн албан шаардлагыг хугацаандаа хэрэгжүүлэх.

Тайлан бичсэн:
Ахлах аудитор Х.Еркегүл

2015 оны 09 дүгээр сарын 10

Аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн албан тоот



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХЭНТИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс:(976) 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2015.09.17 № 174
танай ____-ы № ____-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ТӨРИЙН
САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
С.ХЭРЛЭНЧИМЭГ ТАНАА

Үндэсний Аудитын газрын 2015 оны төлөвлөгөөнд тусгагдсан "Засгийн газрын тусгай сангуудад хийх аудит"-ын хүрээнд "Орон сууцны сангийн хөрөнгийн зарцуулалтад" хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөл, аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэлийг хүргүүлж байна.

Аудитын тайлангийн төсөлтэй танилцаад саналаа 2015 оны 9 сарын 17-ны дотор хариу ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ЭНХТҮВШИН

Холбогдох байгууллагын санал



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

23119 Чингис, Хэнтий аймаг
Утас/Факс: 70-56-24-12
E-mail: Khentiazdtg@yahoo.com

2015.09.24 № 1/1508
танай ____-ны №____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн аудитын газраас ирүүлсэн "Орон сууцны сангийн хөрөнгийн зарцуулалтад" хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА С.ХЭРЛЭНЧИМЭГ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 09 сарын 25 өдөр Дугаар 36 Өндөрхаан хот

Г Т

Нийцлийн аудитын тайланг
батлах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан "Нийслэл болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторуудад зөвшөөрөх бүрэн эрх"-ийн 5, аймгийн Аудитын газрын Удирдах зөвлөлийн 2015 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн-(Орон сууцны сан, Соёл урлаг хөгжүүлэх сан, Авто замын сан, Дархлаажуулалтын сан)-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Нийцлийн аудитын тайланг Үндэсний Аудитын газарт хүргүүлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад танилцуулахыг ахлах аудитор Х.Еркегүлд даалгасугай.

3. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Б.Наранцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ЭНХТҮВШИН

"Орон сууцны сангийн хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэл

Тайлант огноо: 2014 он

№	нөхцөл байдал			Шалгуур үзүүлэлт /Зөрчсөн хууль тогтоомж/		Аудитад үзүүлэх нөлөө (их, дунд, бага)	Дүгнэлт		
	Хийгдсэн ажил	зөрчлийн утга	Мөнгөн дүн сая.төг	Хууль тогтоомж, зүйл заалт	Заалтын утга		Арга хэмжээний санал	Удирдлагын тайлбар	Эцсийн шийдвэр
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Аймгийн Засаг даргын 2014 оны А/618 дугаар захирамжаар аймгийн ЗДТГ-ын 2 мэргэжилтэнд санхүүгийн дэмжлэг олгосон	Орон сууцны сангийн хөрөнгийг зарцуулах журам батлагдаагүй байхад 5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг аймгийн Орон сууцны сангаас олгосон.	5.0	ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол 2013.12.13 өдрийн №108	"Орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих Орон сууц сангийн хөрөнгийг зарцуулах журам боловсруулан 2014 оны 1 дүгээр сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулах..."	бага	Зөвлөмж өгөх	9.24-ний 3/1101 тоотоор санал авсан	Зөвлөмж өгөх
2	Төрийн албан хаагчдаас авах 10.2 сая төгрөгийн авлагыг "Орон сууц худалдах, худалдан авах гэрээ"-ний төлбөр төлж дуусгах хугацаа дууссан байхад барагдуулаагүй байна.	Гэрээний хугацаа дууссан байхад гэрээний үүргээ биелүүлээгүй төрийн албан хаагчдаас авах 10.2 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй.	10.2	Төсвийн тухай хуулийн 6.4.8	"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"	бага	Албан шаардлага өгөх	9.24-ний 3/1101 тоотоор санал авсан	Албан шаардлага өгөх
3	2011 онд 211.0 сая төгрөг, 2012 онд 68.0 сая төгрөг, 2012 онд Д. Одгэрэлээс аймгийн Орон сууцны санд төлөх зээлийн эргэн төлөлт нь данс андууран Тулга зонстракшн ХХК-ний дансанд орсныг авлагаар бүртгэсэн зэрэг нийт 308.6 сая төгрөгийн авлагын тооцоонд 2013 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Хэрлэн суманд баригдах 96 айлын орон сууцнаас төрийн албан хаагчдад зориулж 8 айлын орон сууц захиалах талаар гэрээ байгуулсан.	Тулга констракшн ХХК-тай байгуулсан гэрээний хугацаа дууссан байхад гэрээний үүргээ биелүүлээгүй, хөрөнгөө татаж авах талаар арга хэмжээ аваагүй, авлагын үлдэгдлийг барагдуулаагүй.	308.6	Төсвийн тухай хуулийн 6.4.8	"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"	их	Албан шаардлага өгөх	9.24-ний 3/1101 тоотоор санал авсан	албан шаардлага өгөх
4									
	ДҮН		326.8						

Аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэл хөтөлсөн: Ахлах аудитор Х.Еркегүл Огноо: 2015.09.14

Аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэлийг зөвшөөрсөн:

Байгууллагын дарга _____ / / Огноо _____

Байгууллагын нягтлан бодогч _____ / / Огноо _____

Зөвшөөрөөгүй бол шалтгаалах бичиг _____

Анхан шатны хяналт хийсэн аудитын менежер : Б.Наранцэцэг Огноо _____

Аудитын менежерийн санал: _____

Хоёр дахь шатны хяналт хийсэн Тэргүүлэх аудитор: Ц.Энхтүвшин Огноо 15.09.25

Тэргүүлэх аудиторын санал: _____